



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/151

Мандалговь

Өвсний нөөц бүрдүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2021 оны босго үнэ шинэчлэн батлах тухай 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2021-2022 оны өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй байдал үүсэх, зах зээл дээрх өвсний нийлүүлэлт хомс болж болзошгүй зэрэг онцгой нөхцөл байдал, зайлшгүй хэрэгцээ шаардлагыг харгалзан хөдөө аж ахуй өвөлжилтийн бэлтгэлийг хангах зорилгоор 30 тонн өвсний нөөцийг бүрдүүлсүгэй.

2. Нөөц бүрдүүлэхэд шаардагдах 20,000,000 /Хорин сая / төгрөгийг Мал хамгаалах сангаас зарцуулахыг нягтлан бодогч (Н.Саранзаяа)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох стандартын шаардлага хангасан өвсийг хүлээн авч нөөц бүрдүүлэхийг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), Хөдөө аж ахуйн тасгийн дарга (Ш.Бямба) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.БАТ-ОРГИЛ

